

## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ УРИЛГА

Он, сар, өдөр: 2023-02-28

Сонгон шалгаруулалтын нэр: Агаарын хөлгийн ачаа тээшний туузан дамжуулагч (1 багц)

Сонгон шалгаруулалтын дугаар: GHD-2023/32

“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК нь “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагаанд шаардлагатай “Агаарын хөлгийн ачаа тээшний туузан дамжуулагч(1 багц)” нийлүүлэх зорилгоор битүүмжилсэн иж бүрэн санал ирүүлэхийг урьж байна.

1. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн эрх бүхий оролцогч нь энэхүү урилгад заасан холбоосоор Захиалагчаас ажлын өдрүүдэд 08:00-16:00 цагийн хооронд нэмэлт мэдээлэл авч болно.
2. Сонирхсон оролцогч нь Захиалагчид бичгээр эсхүл цахим шуудангаар хүсэлт гаргаж, 55,000 (тавин таван мянга) (НӨАТ орсон) төгрөгтэй тэнцэх хураамжийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр төлснөөр Англи, Монгол хэл дээр бэлтгэгдсэн Сонгон шалгаруулалтын баримт бичгийг цаасаар эсхүл .pdf өргөтгөлтэй файл хэлбэрээр худалдан авч болно. Төлбөрийг Захиалагчийн Голомт банкны 8125100892 тоот дансанд шилжүүлж /гүйлгээний утга дээр аж ахуй нэгжийн нэр, байгууллагын регистрийн дугаар бичнэ/ төлбөрийн баримтыг хүсэлтийн хамт ирүүлнэ үү.

*\*Цахим шуудангаар илгээсэн хүсэлт ирээгүй, хугацаа хоцорч ирсэн, төлбөрийн баримт хаягдсан, баримт бичиг тодруулаа хугацаа хоцорч хүргээгдсэнтэй холбоотойгоор Захиалагч ямар нэг хариуцлага хүлээхгүй.*

3. Сонгон шалгаруулалтанд ирүүлэх саналаа **2023 оны 3 дугаар сарын 20-ны 13:00** цагт эсхүл түүнээс өмнө урилгад заасан хаягаар ирүүлнэ. Хугацаа хоцорсон саналыг хүлээн авахаас татгалзана. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн саналуудыг Чингис хаан Олон улсын нисэх буудлын Захиргааны барилгын 2 давхар 201 тоотод **2023 оны 3 дугаар сарын 20-ны 13:30** цагт бүртгэж, нийтэд мэдээлэх ба сонгон шалгаруулалтад оролцогчид, тэдгээрийн төлөөлөл, сонирхсон бусад этгээд оролцох эрхтэй.
4. Санал бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор сонгон шалгаруулалтад оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Захиалагч хариуцахгүй.
5. Ирүүлсэн саналуудыг нээх, үнэлэх, гэрээ байгуулах эрх олгохдоо Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасныг дагаж мөрдөнө.

“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК

Хаяг: Монгол улс, Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р баг, Эрдэнэ-Уул 41090, Тахилт толгой Холбоо барих утас, цахим шуудан: [71287422, [procurement-2@nubia-llc.mn](mailto:procurement-2@nubia-llc.mn)]